

БАТЛАВ
 МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
 Я. САРВАНГАЯА
 Я. СОДБААТАР
 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

2021 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ, ӨДӨРЛӨГИЙН ХУВААРЬ

А/А	Нэгдсэн арга хэмжээний нэр		2021 он											
			1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
1	"Эрчим хүч, ус дулаан хангамжийн салбарын тогтвортой ажиллагааг, ам эхгүйн нэгж, байгууллага айл өрхийн тал түймрийн аюулгүй байдлыг хангуулах" нэгдсэн арга хэмжээ	Хамтран ажиллах байгууллага	■	■	■	■	■							
2	Өвөлжилт, хаваржилт хундрах болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ		■	■	■	■	■					■	■	■
3	Шар усны үеэрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ				■	■	■							
4	Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ							■	■	■	■			
5	Газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх, таныулах өдөрлөг				■									
6	Гамшигийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөрлөг												■	
7	Олон улсын Иргэний хамгаалалтын өдөрлөг				■									

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД
2020 оны 12 дугаар сарын 4 өдөр

**ҮЕР, УСНЫ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, голомтод үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, ард иргэдэд сэрэмжлүүлэг, сурталчилгааг шат дараатай зохион байгуулж, бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Гамшгаас хамгаалах тухай, Засгийн 2015 оны 286 дугаар тогтоол "Ус цаг агаар, орчны аюултай, гамшигт үзэгдлийн талаар урьдчилан сэргийлэх мэдээ дамжуулах журам", Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоол "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого", Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл нь эрх зүйн үндэс болно.

2.2. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад дээрх хууль тогтоомж, энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

2.3. Энэхүү нэгдсэн арга хэмжээний хүрээнд ард иргэд, айл өрхүүдэд болзошгүй үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

2.4. Ард иргэд, айл өрхүүдэд сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгаа явуулах, гарын авлага, видео шторкыг албаны www.nema.gov.mn цахим хуудаснаас татаж авна.

**Гурав. Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах
бүрэлдэхүүн**

- 3.1. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс
- 3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар
- 3.3. Ус цаг уур, орчны шинжилгээний газар
- 3.4. Аймаг, нийслэлийн Цагдаагийн газар
- 3.5. Хүнс, хөдөө аж ахуйн газар
- 3.6. Улаанбаатар төмөр зам ХНН
- 3.7. Монголын улаан загалмай нийгэмлэг
- 3.8. Аймаг, нийслэлийн Авто тээврийн төв

Дөрөв. Хугацаа, хамрах хүрээ

4.1. Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулна.

4.2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны ард иргэд, айл өрхөд чиглэгдэнэ.

Тав. Зохион байгуулагдах үйл ажиллагаа

- 5.1 Аймаг, дүүрэг, сум, хорооны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх.
- 5.2. Онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллага, Гамшгаас хамгаалах орон нутгийн албадын үер, усны аюулын голомтод үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийн бэлтгэл,

бэлэн байдалд үзлэг шалгалт хийж, шаардлагатай завь, аврах хантаазны нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

5.3. Голын ай, сав, гуу жалга, үерийн усны буулт бүхий газраар нутаглаж, суурьшсан айл өрхөд нүүн шилжих тухай шаардах хуудсыг хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх ажлыг нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

5.4. Орон нутгийн төр захиргааны болон мэргэжлийн байгууллагатай хамтран далан, суваг, ус нэвтрүүлэх нүхэн гарцын хогийг цэвэрлэх, онгойлгох, гэрийг өндөрлөг цэгт бариулах, гэр хашаандаа шуудуу татуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах.

5.5. Усархаг бороо орох үеэр хот хоорондын болон орон нутгийн зорчигч тээврийн хэрэгслийг үер усны буулт бүхий газраар явуулахгүй байх, шаардлагатай тохиолдолд хөдөлгөөнийг түр хязгаарлах, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, зорчигчдын аюулгүй байдлыг хангуулах, авто вокзалуудад анхааруулга сэрэмжлүүлэг өгч, хяналт тавьж хамтран ажиллах.

5.6. Томоохон гол, мөрөн, нуур, цөөрөм дагуу Цагдаагийн байгууллага, Монголын улаан загалмай нийгэмлэгийн дунд шатны хороотой хамтран эргүүл ажиллуулж, амарч, зугаалж буй иргэдэд сэрэмжлүүлэг, мэдээлэл өгөх.

5.7. Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг шторк бэлтгэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайтаар иргэдэд хүргэх.

5.8. Иргэд олноор цуглардаг амралт, зугаалгын газар, гол, мөрөн, нуур, цөөрөм, усны осол гарч болзошгүй газруудад үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, тэмдэг, тэмдэглэгээ, самбарыг батлагдсан стандартын дагуу аймаг тус бүр 8-10-ийг шинээр байрлуулах, хуучирч муудсан тэмдэг, тэмдэглэгээг сэргээх арга хэмжээг авах.

5.9. Иргэд олноор цуглардаг амралт, зугаалгын газруудад үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих.

5.10. Ард иргэд, айл өрхүүдэд болзошгүй үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг шат дараатай зохион байгуулах, хүн ам олноор цуглардаг зах, худалдааны төв, үзвэр үйлчилгээний газруудад сурталчилгааны самбар байршуулах, санамж, сэрэмжлүүлэг тараах.

5.11. Бага насны хүүхдийг гол, мөрөн, нуур, тогтоол устай газар хараа хяналтгүй орхихгүй, гол усанд тоглуулахгүй байх, иргэд архиан согтуурсан үедээ голын усанд орохгүй байх талаар сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол өгөх.

5.12. Үер, усны аюулын үед гэр хорооллын айл өрхүүдийн бие засах газар усаар дүүрч халин улмаар орчны бохирдол үүсэж, халдварт өвчин гарах нөхцөл бүрддэг тул ариутгал, халдваргүйжүүлэлт хийх.

5.13. Нэгдсэн арга хэмжээний хугацаанд сум, баг, хороо, дүүрэг дээр 3-оос доошгүй удаа өдөрлөг зохион байгуулах.

5.14. Зохион байгуулсан арга хэмжээний дүн, мэдээг 2021 оны 09 дүгээр сарын 20-ний өдрийн дотор, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтний arjunaanema@gmail.com цахим хаягаар гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудсын хамт ирүүлнэ.

Зургаа. Нэгдсэн арга хэмжээний үр дүн, зардал

6.1. Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газраас удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.2. Улсын хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээний талаар дүнг Гамшгаас урьдчилан сэргийлэх газар нэгтгэн дүгнэж, Монгол Улсын Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын даргад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны дотор танилцуулна.

6.3. Нэгдсэн арга хэмжээг явуулахад шаардлагатай зардлыг тухайн шатны Засаг даргын тамгын газрын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал, Онцгой байдлын газар, хэлтэс тус тус санхүүжүүлнэ.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР